



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 09 өдөр

Дугаар A/38

Бор-Өндөр сум

Нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.4, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Сумын хэмжээнд 2026 оны 02 дүгээр сарын 12-ноос 13-ны өдрүүдэд Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулсугай.

2. Нийтийн их цэвэрлэгээнд өөрийн өрх гэр, байгууллагын орчин тойрон, хариуцуулж өгсөн нийтийн эзэмшлийн хуваарьт талбайг цэвэрлэж идэвх санаачилгатай оролцохыг нийт иргэд, аж ахуй нэгж, албан байгууллагын дарга эрхлэгч, багийн засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Нийтийн их цэвэрлэгээнд оролцоогүй албан байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох бөгөөд албан байгууллагын дарга, эрхлэгч нарт уг захирамжийн биелэлтийг хэрхэн хангаж ажилласнаар хагас, бүтэн жилийн үр дүнгийн гэрээг дүгнэхийг мэдэгдсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Засаг даргын Орлогч (Х.Галбадрах) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ